УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ФОРВАРД ГЭРЭЭНИЙ АРИЛЖААНЫ ЗАР

<table>
<tr><td>1</td><td>Худалдагч этгээдийн нэр</td><td>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ</td></tr>
<tr><td>2</td><td>Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг</td><td>2026-11-25
15:00</td></tr>
<tr><td>3</td><td>Уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал</td><td>22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмал, ангиллын код: 2603.00.20</td></tr>
<tr><td>4</td><td>Чанарын үзүүлэлт</td><td><table><tr><th>Хэмжигдэхүүн</th><th>Чанарын үзүүлэлт</th></tr><tr><td>Зэс /Cu/</td><td>22.35%</td></tr><tr><td>Мөнгө /Ag/</td><td>78 гр/тн</td></tr><tr><td>Хүнцэл /As/</td><td><0.3%</td></tr><tr><td>Чийглэг /moisture/</td><td>9.4%</td></tr><tr><td>Молибден /Mo/</td><td><0.15%</td></tr><tr><td>Төмөр /Fe/</td><td><30%</td></tr><tr><td>Цайр /Zn/</td><td><0.7%</td></tr><tr><td>Хар тугалга /Pb/</td><td><1.4%</td></tr><tr><td>Хүхэр /S/</td><td><37%</td></tr><tr><td>Алт /Au/</td><td><0.3 гр/тн</td></tr><tr><td>Хөнгөн цагаан /Al/</td><td><2.0%</td></tr></table></td></tr>
<tr><td>5</td><td>Багцын тоо, нийт хэмжээ</td><td>7,000 НМТ /нойтон метр тонн/
6,342 ХМТ /хуурай метр тонн/</td></tr>
<tr><td>6</td><td>Дуудах доод үнэ, валютын төрөл</td><td>3,231.30 ам.дол/ХМТ</td></tr>
<tr><td>7</td><td>Тогтмол үнэтэй эсхүл индексэд суурилсан үнэтэй захиалга эсэх</td><td>Тогтмол</td></tr>
<tr><td>8</td><td>Чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралт байгаа эсэх, тооцох аргачлал</td><td>Хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахаас баяжмал ачигдах үед ойролцоогоор 500НМТ баяжмал тутмаас химийн агуулга тодорхойлох дээжийг олон улсын стандартын дагуу бэлтгэнэ.
Хөндлөнгийн хяналтын байгууллагын тодорхойлсон агуулга дээр үндэслэн баяжмалын үнэд залруулга хийнэ.</td></tr>
<tr><td>9</td><td>Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн</td><td>5 ам.доллар</td></tr>
<tr><td>10</td><td>Гэрээ дуусгавар болох хугацаа</td><td>2027 оны 3 дугаар сарын 31</td></tr>
<tr><td>11</td><td>Хүргэлт хийх хугацаа, нөхцөл /хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд хүргэлтийн хуваарь/</td><td>Нийлүүлэлтийг 2027 оны 1-р сарын 31-ээс өмнө хийнэ.
DAP (Инкотермс 2020, түүнд орсон нэмэлт өөрчлөлт)
Монгол-Хятадын хил (Эрээн)</td></tr>
<tr><td>12</td><td>Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг</td><td>БНХАУ-ын Эрээн өртөө, зэсийн баяжмал ачих, буулгах талбай</td></tr>
<tr><td>13</td><td>Тээвэрлэлтийн төрөл</td><td>Төмөр зам</td></tr>
<tr><td>14</td><td>Дэнчингийн хэмжээ</td><td>10% буюу 2,049,290.46 ам.дол
Брокероор дамжсан тохиолдолд 5% буюу 1,024,645.23 ам.дол</td></tr>
<tr><td>15</td><td>Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл</td><td>1.Хүлээн авагч：MONGOLIAN STOCK EXCHANGE JSC
Хүлээн авагчийн банк：XACBANK
Свифт код: CAXBMNUB
Дансны дугаар: MN 6400 3200 5005595301
Банкны хаяг：ULAANBAATAR XACBANK HQ BLDG,</td></tr>
</table>

		ULAANBAATAR-14200 2. Хүлээн авагч: MONGOLIAN STOCK EXCHANGE JSC Хүлээн авагчийн банк: GOLOMT BANK Свифт код: GLMTMNUB Дансны дугаар: MN 9700 1500 1105041063 Банкны хаяг: HEAD OFFICE OF GOLOMT BANK, D.SUKHBAATAR SQUARE 5, P.O.BOX 22, ULAANBAATAR 15160, MONGOLIA
16	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл	Худалдагч болон Худалдан авагч нь арилжаа явагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор зэсийн баяжмалын худалдах, худалдан авах гэрээг байгуулна. Худалдан авагч нь төмөр замын ачилтын зааврыг ачилт явагдах сарын өмнөх сарын 15-ны өдрөөс өмнө бичгээр мэдэгдэнэ. Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмалын хайлуулах, цэвэршүүлэх зардлыг CRU судалгааны байгууллагын Copper Raw Materials сэтгүүлээс зарлагдсан 2026 оны урт хугацааны жилийн гэрээний жишиг үзүүлэлтийг үндэслэнэ.
17	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар	976-11-313315 (6113)

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа	2027 оны 1 дүгээр сар	
Төлбөр төлөх хугацаа	Худалдагч урьдчилгаа нэхэмжлэх бэлтгэн цахим шуудангаар Худалдан авагчид хүргүүлэх бөгөөд нэхэмжлэхийг гаргасан өдрөөс хойш Худалдан авагч банкны ажлын таван өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ.	
Нийлүүлэх хэмжээ /тонн/	7,000 НМТ	6,342 ХМТ

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад хэл дээрх зарын мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

---oOo---

ERDENET
Mining Corporation

Erdenet City, Mongolia Tel:(976 7573791); Fax: (976 70353002)

Pro-forma Invoice No:….. MSE-2026/11-Cu

Buyer:
Contract No: MSE-2026/11-Cu
Goods: Copper concentrates
Delivery: DAP Incoterms 2020 Mongolian-Chinese border at Erlian
Shipped to: Erlian railway station, China
Shipment period: Jan-27

Net Wet Weight:			7,000.00	WMT	
Moisture:			9.40	%	
Net Dry Weight:			6,342.00	DMT	
Assays, Provisional		Copper, (Cu):	22.35	%	
		Silver, (Ag):	78.00	Grams/DMT	
		Arsenic, (As):	0.30	%	
Price: Average for 17 October to 15 November 2026		Cu:	14,244.63	USD/MT	
		Ag:	53.010	USD/Oz	
Contained Cu Price per DMT	(22.35 -0.5) * 14244.63 USD		=	3,112.45	USD
Contained Ag Price per DMT	78.000* 90 % / 31.1035 =		2.2570	Oz	
	(53.010-0.35 USD) * 2.2570 Oz		=	118.85	USD
Deduct: T/C:			=	-	USD
R/C:			=	-	USD
As:	(0.30 - 0.30) % * 2.0 USD / 0.10 %		=		USD
Unit Price per DMT:			=	**3,231.30**	USD
Auction unit price increase					
Executed unit price				**3,231.30**	
Total Amount:	6,342.000 DMT * 3,231.30 USD		=	**20,492,904.60**	USD
Collateral amount paid to MSE deductable:				**2,049,290.46**	USD
Total Payment to EMC:				**18,443,614.14**	USD

Signature

Signature

Signature

ГЭРЭЭ № MSE-2026/11-Cu

Эрдэнэт хот, Монгол

Энэхүү зэсийн баяжмал худалдах, худалдан авах гэрээг (цаашид “Гэрээ” гэх)

2026 оны 11-р сарын 25-ны өдөр

нэг талаас:

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**,
Бүртгэлийн хаяг: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай 61027 (цаашид “**Худалдагч**” гэх)

нөгөө талаас:

Худалдан авагч

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО:

Монголын Хөрөнгийн биржийн 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн .... тоот хэлцлийн дагуу арилжаалагдсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хөвүүлэн баяжуулж үйлдвэрлэсэн зэсийн баяжмалыг (цаашид “баяжмал” гэх) дор дурдсан нөхцөлөөр Худалдагч худалдах, Худалдан авагч худалдан авахаар тохиролцов:

1. НЭР ТОМЬЁО

Энэхүү гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томьёо, тодорхойлолтууд нь доор дурдсан утгатай байна. Үүнд:

- “Тонн” болон “Метр Тонн” гэсэн нэр томьёо нь 1000 кг эсвэл 2204.62 фунттай тэнцүү байна;

- “ХМТ” нь хуурай метр тонн, “НМТ” нь нойтон метр тонн гэсэн утгатай байна;

CONTRACT № MSE-2026/11-Cu

Erdenet, Mongolia

This Contract on Sales and Purchase of Copper Concentrates (hereinafter the “Contract”) is made

on this day 25th of November, 2026.

by and between:

Erdenet Mining Corporation SOE, a legal entity organised and operating under the laws of Mongolia with its registered address at: 61027 Nairamdal square, Bayan-Undur soum, Orkhon aimag, Mongolia (hereinafter the “**Seller”**)

And

Buyer’s name

SUBJECT OF THE CONTRACT:

The Buyer agrees to buy, and the Seller agrees to sell copper flotation concentrates (hereafter the referred to as “the Concentrates”) produced by Erdenet Mining Corporation SOE, traded under the Agreement No ..... of Mongolian Stock Exchange on 25 November 2026, on the following terms and conditions:

1. DEFINITIONS:

The following terms and expressions, used in this Contract shall have the meanings set out below:

- The term “Tonne” and “Metric Ton” each means 2204.62 Pounds or 1000 kilograms.

- The terms “DMT” and “WMT” mean Dry Metric Ton and Wet Metric Ton respectively.

- “Нэгж” гэсэн нэр томьёо нь хуурай метр тонны нэг хувь гэсэн утгатай байна;

- “Жил” гэдэг нь тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусах дараалсан 12 сарын хугацааг хэлнэ;

- “Унци” буюу “oz” гэдэг нь 31.1035 граммтай тэнцүү хэмжигдэхүүнийг хэлнэ;

- “PPM” болон “гр/тонн” гэдэг нь саяны нэг буюу 1 метр тоннд 1 граммтай тэнцүү байна;

- “Фунт” буюу “lb” гэдэг нь 453.593 граммтай тэнцүү хэмжигдэхүүнийг хэлнэ.

- Доллар болон цент гэдэг нь Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт болох доллар болон центээр (доллар ба цент) илэрхийлэгдэнэ.

- The term “Unit” means 1% of the net dry weight.

- The term “Year” means a period of 12 consecutive months commencing 1st January and ending 31st December of the concerned year.

- The term “Ounce” or “oz” means a troy ounce or equal to 31.1035 grams.

- The term “PPM” or “g/MT” means part per million or 1 gram per Metric Ton.

- The term “Pound” or “lb” means one pound equal to 453.593 grams.

- Dollar and cents ($ and ¢) are references to the currency of the United States of America.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:

2.1. Энэхүү Гэрээ болон түүний Нэмэлтүүд нь талууд гарын үсэг зурж, тамга дарагдсан өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд 2027 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

2. DURATION:

2.1.This Contract and all Amendments there to shall enter into force from the date of signing and stamping by both Parties and shall remain in force until the 31 March, 2027.

3. ТОО ХЭМЖЭЭ:

3.1.Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх баяжмалын тоо хэмжээ нь 7,000 НМТ байна.

3. QUANTITY:

3.1.The quantity of the Concentrates to be delivered under this Contract shall be 7,000 WMT .

4. ЧАНАР:

4.1. Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмал “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хөвүүлэн баяжуулах аргаар Монгол улсад үйлдвэрлэсэн байх бөгөөд чанар нь дараах химийн бүтэцтэй байна:

4. QUALITY AND DESCRIPTION:

4.1 The Concentrates to be delivered under this Contract shall be a flotation copper concentrate produced by the Erdenet Mining Corporation SOE in Mongolia with the following chemical composition:

Erdenet Mining Corporation SOE

Buyer’s name

Химийн элемент	Агуулга
Cu	22.35%
Mo	<0.15%
Fe	<30%
Zn	<0.7%
Pb	<1.4%
As	<0.3%
S	<37%
Ag	78g/t
Au	<0.3 g/t
Al	<2.0%
Чийглэг	9.4%

Characteristic	Content
Cu	22.35%
Mo	<0.15%
Fe	<30%
Zn	<0.7%
Pb	<1.4%
As	<0.3%
S	<37%
Ag	78g/t
Au	<0.3 g/t
Al	<2.0%
W moisture	9.4%

4.2. Бүтээгдэхүүн нь хайлуулах явцад хор учруулах аливаа хорт бодис болон ямар нэгэн хатуу биет агуулаагүй байна.

4.2. The concentrate shall be free of impurities deleterious to the smelting process, and extraneous solids.

4.3. Баяжмалд ямар нэгэн хортой бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хэмжээнд илэрсэн тохиолдолд талууд харилцан зөвшилцөж, асуудлыг шийднэ. Худалдан авагч баяжмалыг авахаас татгалзах эрхгүй.

4.3. In case of detection of any other impurities, exceeding the allowed limits, both Parties shall discuss and resolve the matter. However, the Buyer shall have no right to refuse the delivery of the concentrates.

5. **НИЙЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ**

5. DELIVERY:

5.1. Баяжмалыг Монгол-Хятадын хил DAP Эрээн (Инкотермс 2020, түүнд орсон нэмэлт өөрчлөлт) нөхцөлөөр төмөр замын вагоноор нийлүүлнэ.

5.1. The Concentrate shall be delivered to DAP Erlian (Incoterms 2020 and any amendments thereto) on railway cars Mongolian/Chinese border (Erlian).

5.2. Баяжмал нь буцаан олгогдохгүй нөхцөлтэй тус бүр 2.5-3.5 метр тонны багтаамжтай том уутанд савлагдан ачигдана.

5.2. The Concentrate shall be delivered in non-returnable big bags of 2.5-3.5 metric tons each.

6. АЧИЛТ:

6. SHIPMENT:

6.1. Худалдагч нь энэхүү гэрээний дагуу ачигдах баяжмалыг энэхүү гэрээний 8.2-р заалтын дагуу урьдчилгаа төлбөрийг Худалдан авагч төлснөөс хойш 7 өдрийн дотор багтаан ачилтыг эхлүүлнэ.

6.1. The Seller shall commence the shipment not later than 7 days from the date of the Buyer's provisional payment, made in accordance with Clause 8.2 of this Contract.

Erdenet Mining Corporation SOE

Buyer's name

6.2. Худалдан авагч нь хайлуулах үйлдвэр баяжмалыг хуваарийн дагуу хүлээн авахад бэлэн байгааг Худалдагчид мэдэгдэж төмөр замын ачилтын зааврыг ачилт явагдах сарын өмнөх сарын 15-ны өдрөөс өмнө бичгээр мэдэгдэнэ.

6.2. The Buyer shall present and inform the Seller in writing Railway Bill Instructions and the readiness of receipt of the concentrate by receiving smelter within first 15 days of the month prior to the scheduled month of shipment.

6.3. Худалдан авагч заасан хугацаанд ачилтын зааврыг ирүүлээгүй тохиолдолд Худалдагч ачилтыг цуцлах эрхтэй.

6.3. In case the Buyer fails to inform the RWBill Instructions within the stated period, the Seller has the right to cancel the shipment.

6.4. Ачилт дууссанаас хойш ажлын 5 өдөр дотор Худалдагч дараах баримт бичгүүдийн хуулбарыг Худалдан авагчид цахим шуудангаар илгээнэ.

- Вагон тус бүрийн дугаар, жин зэргийг багтаасан ачилтын мэдээ;
- Төмөр замын падаан;
- Ачигдсан баяжмалын жин, чанарын гэрчилгээ.

6.4. Within 5 working days following the date of shipment, the Seller shall forward to the Buyer, the copy of the following documents by email:

- Shipping details, including r/w bill numbers and weight of each railway car.
- Railway bills.
- Quality and quantity certificate on the dispatched Concentrates

7. БАЯЖМАЛЫН ҮНЭ:

7. CONCENTRATE PRICE:

7.1. Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмалыг тогтмол үнийн нөхцөлөөр арилжаална.

7.1. The copper concentrate to be delivered under this Contract shall be traded under fixed price terms.

7.2. Зэсийн баяжмалын дуудах доод үнэ:
Монголын Хөрөнгийн биржийн 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн.....тоот хэлцлийн дагуу худалдсан, нэг хуурай метр тонн /ХМТ/ зэсийн баяжмалын дуудах доод үнэ 3,231.30 ам.доллар байна.
Биржийн арилжааны дуудах доод үнийг арилжааны захиалга өгөх өдрийн өмнөх хуанлийн 7 хоног болон 30 хоногийн Лондонгийн Металлын Биржийн дундаж үнийн аль өндрийг үндэслэн тогтооно.

7.2. The call price of the copper concentrate:
The call price per dry metric ton /DMT/ of copper concentrates traded under Agreement No.…. of the Mongolian Stock Exchange dated 25 November 2026 shall be USD 3,231.30 .

The Call Price of concentrate on the exchange auction is calculated based on the higher of the 7-day or 30-day LME cash settlement average metal prices prior to the trading order submission date.

7.3. Урьдчилгаа төлбөрийн нэгж үнэ:
Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх 1 (нэг) хуурай метр тонн зэсийн баяжмалын урьдчилгаа төлбөрийн нэгж үнэ нь Монголын

7.3. Provisional Unit Price:
The provisional unit price per 1 (one) dry metric ton of copper concentrate to be delivered under this

Erdenet Mining Corporation SOE

Buyer’s name

Хөрөнгийн Биржийн арилжаанаас тогтоогдсон хэлцлийн үнэ байна.

7.4. Эцсийн төлбөрийн нэгж үнэ:
Тогтмол үнийн нөхцөлөөр арилжаалсан 1 (нэг) хуурай метр тонн баяжмалын эцсийн нэгж үнийг дуудах доод үнэ тооцсон Лондонгийн Металлын Биржийн (LME) зэсийн үнэ болон Лондонгийн Үнэт Металлын Зах Зээлийн Холбооны (LBMA) мөнгөний үнийг үндэслэн тооцсон баяжмалын үнэ дээр биржийн арилжааны үнийн өсөлтийг нэмж тооцно.
Энэхүү эцсийн нэгж үнийг тооцохдоо 11 дүгээр зүйлийн дагуу тогтоосон жин, чийглэгийн эцсийн дүн, 12 дугаар зүйлийн дагуу баталгаажсан зэс болон дагалдах металлын химийн эцсийн агуулга дээр үндэслэн эцэслэн тодорхойлно.

7.5. Зэсийн баяжмалын үнийг дараах нөхцөлөөр тооцно. Үүнд:
Металлын хасалт:
- Зэсийн агуулгаас 0.5 нэгжийг хасаж тооцно.
- Мөнгөний агуулгын 90%-д төлбөр тооцно.

Мөнгөний цэвэршүүлэх зардал: 1 унци төлөгдөх мөнгө тутмаас 0.35 ам доллар хасаж тооцно.
Баяжмал дахь хорт бодис арсеникийн агуулга 0.30 % -иас дээш гарсан тохиолдолд 0.30%-иас илүү гарсан 0.10% тутамд 2.00 ам долларыг хасаж тооцно.

7.6. Хайлуулах, цэвэршүүлэх зардал:
Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмалын хайлуулах, цэвэршүүлэх зардлыг CRU судалгааны байгууллагын Copper Raw Materials сэтгүүлээс зарлагдсан 2026 оны урт хугацааны жилийн гэрээний жишиг үзүүлэлтийг үндэслэнэ.
Зэсийн хайлуулах зардал: 0 ам. доллар/ХМТ
Зэсийн цэвэршүүлэх зардал:0 ам. доллар/ХМТ

contract shall be the transaction price determined at the Mongolian Stock Exchange auction.

7.4. Final Unit Settlement Price:
The final unit price per 1 (one) dry metric ton of concentrate traded under fixed price terms shall be calculated by adding the auction price premium achieved during exchange trading to the concentrate price determined based on the London Metal Exchange (LME) copper price and the London Bullion Market Association (LBMA) silver price used in calculating the minimum call price.

Such final unit price shall be definitively calculated by incorporating the final weight and moisture determined under Clause 11, the certified actual chemical assays of copper and payable metals under Clause 12.

7.5. The price for copper concentrate shall be calculated based on the following terms and conditions:
Metal deduction:
- 0.5 units from the copper content
- Pay for 90% of the silver content

Refining charge Ag: deduct US¢35 per troy ounce of payable silver.

In case the arsenic contents is more than 0.30%, arsenic deduction of US$2.00 per DMT is applied for each 0.1% that exceeds 0.30%

7.6. Treatment and Refining Charges
The treatment and refining charges for the copper concentrate to be delivered under this contract shall be based on the annual long-term contract benchmark for 2026 published in CRU Group Copper Raw Materials publication.

Treatment charge Cu: 0.0 US$/DMT
Refining charge Cu: 0.0 US$/DMT

8. ТӨЛБӨР:

8.1. Бүх нэхэмжлэх болон авлагын мэдэгдэл зэрэг нь ам. доллар, центээр байх бөгөөд бүх төлбөрийг АНУ–ын доллар, центээр нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

8.2. Урьдчилгаа төлбөр

Худалдагч урьдчилсан нэхэмжлэх болон ачилт бэлэн болсон тухай мэдэгдлийг бэлтгэн факсаар буюу цахим шуудангаар Худалдан авагчид хүргүүлэх бөгөөд Худалдан авагч нэхэмжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ.

Худалдагч Монголын Хөрөнгийн биржид Худалдан авагч компанийн төлсөн дэнчингийн төлбөрийг хасаж урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэхийг бэлтгэнэ.

Төлбөрийг дээр дурдсан хугацаанд багтаан шилжүүлээгүй тохиолдолд Худалдагч энэхүү гэрээний дагуу нийлүүлэх баяжмалын ачилтыг цуцлах эрхтэй.

8.3. Эцсийн төлбөр

a) Худалдагч нь энэхүү гэрээний 7.4 дэх заалтын дагуу тодорхойлсон эцсийн нэгж үнийг үндэслэн тооцсон эцсийн төлбөрөөс Худалдан авагчийн урьдчилгаа төлбөр болон тухайн нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд хамаарах дэнчингийн төлбөрийг суутган эцсийн нэхэмжлэхийг бэлтгэнэ.
b) Эцсийн нэхэмжлэхийн дагуу гарсан төлбөрийг нэхэмжлэх бэлтгэгдсэнээс хойш ажлын 5 өдөрт багтаан Худалдагч эсвэл Худалдан авагч эцсийн төлбөрийг шилжүүлнэ.

8. PAYMENT:

8.1. All invoices or credit notes shall be in Dollars and Cents, and all payments shall be made by telegraphic transfer in Us Dollars and Cents, according to the Invoices.

8.2. Provisional payment

The Seller shall make a provisional invoice for the concentrates and to be sent to the Buyer by fax or e-mail. The Buyer shall make a provisional payment within 5 banking days from the date of the Seller's provisional invoice and Notice of Readiness.

Seller shall deduct the collateral amount paid by Buyer to the Mongolian Sock Exchange from the provisional invoice.

In the case of non-payment within the abovementioned period, the Seller has the right to cancel the shipment concentrates to be delivered under this Contract.

8.3. Final Payment

a) The Seller shall issue the final invoice based on the final settlement amount calculated in accordance with the final unit price defined in Clause 7.4 hereof, net of the Buyer's provisional payment and the portion of the collateral deposit attributable to the delivered product quantity.
b) The final payment according to the final invoice shall be made by Buyer or Seller within 5 banking days after the final invoice date.

9. ӨМЧЛӨХ ЭРХ БА ЭРСДЭЛ:

9. TITLE AND RISK:

_____ _____

Erdenet Mining Corporation SOE Buyer's name

9.1. Баяжмалыг өмчлөх эрх нь энэхүү гэрээний 8-р зүйлийн дагуу тухайн ачилтын урьдчилгаа төлбөрийг Худалдагч хүлээн авснаар Худалдан авагчид шилжинэ.
9.2. Ачааны вагон Монгол/Хятадын хилийн зурвасыг нэвтэрснээр эрсдэл Худалдан авагчид шилжинэ.

9.1. The title to the Concentrate shall pass from the Seller to the Buyer upon provisional payment being received by the Seller in accordance with Clause 8 hereof.
9.2. The risk shall pass to the Buyer at the time when the rail cars with the Concentrates cross Mongolian/Chinese border.

10. ДААТГАЛ:

10.1. Гэрээний 5-р зүйлд дурдсан нийлүүлэх цэг хүртэлх аливаа даатгалын зардлыг Худалдагч хариуцна.

10.2. Нийлүүлэх цэгээс цааш гарсан бүх эрсдэлтэй холбоотой аливаа даатгалын зардлыг Худалдан авагч хариуцна.

10. INSURANCE:

10.1. The insurance up to the point of delivery in accordance with Clause 5 of this Contract shall be the responsibility of the Seller.

10.2. The insurance after the point of delivery shall be the responsibility of the Buyer against all risks.

11. ЖИГНЭЛТ, ДЭЭЖ АВАЛТ, ЧИЙГЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ:

11.1. Баяжмалын жигнэлт, дээж авалт, чийглэг тодорхойлох ажлыг Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэн, Лондонгийн Металлын Биржийн гишүүнчлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахад баяжмал ачигдах үед олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

11.2. Баяжмалын жин, чийглэгийг тодорхойлохдоо нэг лот буюу 500 НМТ баяжмал тутмаас дээж авч олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гэрээний дагуу нийлүүлсэн баяжмалын жин, болон чанар нь лот тус бүрээр тодорхойлогдох бөгөөд ачилтын жин, чанарыг ачилтыг бүрдүүлж байгаа бүх лотны үр дүнг нэгтгэн тооцож тодорхойлно.

11. WEIGHING, SAMPLING AND DETERMINATION OF MOISTURE:

11.1. The weighing, sampling and moisture determination shall be made during the loading process at the Seller’s warehouse according to the established international practice under the control of internationally recognized independent controlling organization accredited by Mongolan Stock Exchange

and member of the London Metal Exchange.

11.2. The weighing and determination of moisture of the Concentrates shall be carried out in lots of approximately 500 WMT according to the established international standards.

The weight and quality shall be determined for each lot and the shipment weight and quality shall be determined comprising all results of lots composing the shipment.

Erdenet Mining Corporation SOE _____ Buyer’s name _____

11.3. Эцсийн хуурай жинг Худалдагчийн агуулахад хөндлөнгийн хяналтын байгууллагын хяналтын дор тодорхойлох бөгөөд энэхүү жинг хоёр тал хүлээн зөвшөөрөх ба эцсийн жин болно.

11.4. Худалдагчийн агуулахад жин, чийглэг тодорхойлох ажилд Худалдан авагч өөрийн зардлаар оролцож болно.

11.3. The final dry weight of the Concentrates shall be determined as the results of weighing and moisture determination at the Seller's warehouse by a controlling organization and shall be the final weight for settlement between the Parties.

11.4. The Buyer's representative may take participation in such weighing and moisture determination at the Seller's warehouse at the Buyer's expense.

11.5. Худалдагчийн агуулахад хөндлөнгийн хяналтын байгууллагын жин чийглэг тодорхойлж дээж авсан үйлчилгээний төлбөрийг Худалдагч хариуцан төлнө.

11.5. The cost for service of a controlling organization on weighing and moisture determination at the Seller's warehouse shall be wholly paid by the Seller.

12. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ:

12. ASSAYS:

12.1. Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэн, Лондонгийн Металлын Биржийн гишүүнчлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахад баяжмал ачигдах үед ойролцоогоор 500 НМТ баяжмал тутмаас химийн агуулга тодорхойлох дээжийг олон улсын стандартын дагуу бэлтгэнэ.

12.1. Internationally recognized independent controlling organization accredited by Mongolan Stock Exchange and member of the London Metal Exchange shall prepare samples in lots of approximately 500 WMT for chemical anallysis during the loading process at Seller's warehouse according to the established international practice.

12.2. Лот тутмаас авсан дээж нь 4 тэнцүү хэсэгт хуваагдан зэс, мөнгө, хүнцлийн агуулгыг тодорхойлох зориулалтайгаар хийгдэх ба дараах байдлаар тараагдана.

- 2 дээжийг энэхүү гэрээний 12.3 заалтын дагуу химийн агуулгын тодорхойлох зориулалтаар хөндлөнгийн хяналтын байгууллагад;
- 2 дээжийг хөндлөнгийн хяналтын байгууллага болзошгүй маргаан таслах химийн агуулгыг тодорхойлох зориулалтаар хадгална.

12.2. The sample for each lot shall be divided into 4 (four) equal portions for the purpose of copper silver and arsenic assays. The samples are distributed as follows:

- 2 sets for controlling organizations for the purpose of chemical analysis in accordance with Clause 12.3 hereof.
- 2 sets for the possible umpire analysis which shall be retained by the controlling organization.

12.3. Хөндлөнгийн хяналтын байгууллага нь зэсийн баяжмалын химийн шинжилгээг хийж, шинжилгээний үр дүнг зэс болон хүнцлийн агуулгыг аравтын 2 оронтойгоор нэг хуурай

12.3. Controlling organizations shall conduct the chemical analysis of the concentrate and the assay results of copper and arsenic will be stated in

метр тоннд хувиар, цагаан мөнгөний агуулгыг аравтын оронгүйгээр нэг хуурай метр тоннд граммаар илэрхийлэн гаргана.

12.4. Хөндлөнгийн хяналтын байгууллагын тодорхойлсон энэхүү шинжилгээний үр дүнг хоёр тал хүлээн зөвшөөрч эцсийн тооцоонд хэрэглэнэ.

12.5. Хөндлөнгийн хяналтын байгууллага химийн шинжилгээний үр дүнг Худалдагч болон Худалдан авагчид цахим шуудангаар эсвэл гараас гарт хүргүүлнэ.

12.6. Худалдагчийн агуулахад дээж авах ажилд Худалдан авагч өөрийн зардлаар оролцож болно.

12.7. Хөндлөнгийн хяналтын байгууллагын химийн шинжилгээ хийсэн үйлчилгээний төлбөрийг Талууд тэнцүү 50/50 хувиар хуваан төлнө.

13. ГЭРЭЭГ ДҮГНЭХ:

13.1. Энэхүү гэрээний 8.3-р заалтын дагуу ачилтын эцсийн нэхэмжлэхийн төлбөр төлөгдсөнөөс хойш 15 хоногийн дотор талууд гэрээ хаах тухай протоколд гарын үсэг зурж гэрээг дүгнэнэ.

14. **ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ:**

14.1. Энэхүү гэрээнд “Давагдашгүй хүчин зүйл” гэж Худалдагч болон Худалдан авагч нь үүргээ гүйцэтгэх боломжгүй болгосон нөхцөл байдал үүсгэсэн Талуудаас үл хамаарах: аливаа дайн, хувьсгал, мөн үер усны аюул, газар хөдлөлт, гал түймэр, салхи шуурга зэрэг Байгалийн хүчин зүйл болон эдгээртэй адилтгаж болох байгалийн бусад үзэгдэл, түүнчлэн ажил хаялт, Үйлдвэрчний байгууллагуудын оролцоо, Засгийн газар болон Засгийн газрын

percentage of DMT, 2 decimal places, and of silver in grams per DMT, no decimal places.

12.4. These assay results so determined by the independent controlling organizations shall be accepted by and applied for the final settlement between both Parties.

12.5. The assay results shall be forwarded by a controlling organization to the Seller and Buyer by an e mail, hand transfer.

12.6. The Buyer’s representative may take participation in sampling at the Seller’s warehouse at the Buyer’s expense.

12.7. The cost for service of an independent controlling organization on chemical analysis shall be born equally by the Parties on 50:50 percent bases.

13. FINALIZATION OF THE CONTRACT:

13.1. The Parties shall sign a Protocol to finalize the Contract within 15 working days from the date of final payment under the Final Invoice of the shipment in accordance with Clause 8.3 this Contract.

14. FORCE MAJEURE:

14.1. For the purpose of this Contract, Force Majeure shall mean any event whatsoever beyond the control of a Party hereto and preventing the Seller or Buyer from performing its obligations under the Contract, including, (but not limited to): any war, revolution, act of God, flood, storm, earthquake, fire, explosion, strike, interference of Trade Unions, act and resolution of Government of Mongolia or decision of Government agencies, prohibiting the shipment or sale of concentrates, obstruction or blockage of railway or delays en route, or restriction or termination of

агентлагаас гаргасан аливаа тогтоол, шийдвэр, баяжмалын худалдаа болон ачилттай холбоотой хориг, төмөр замын доголдол, цахилгааны тасалдал зэрэг хүчин зүйлсийг (үүгээр хязгаарлагдахгүй) хэлнэ.

submission of an electricity (any such cause being hereinafter called "Force Majeure event").

14.2. Давагдашгүй хүчин зүйлээс болж баяжмал нийлүүлэх, эсвэл хүлээн авч чадахгүй болсон тал нь энэ тухайгаа нөгөө талдаа 10 хоногийн дотор багтаан бичгээр мэдэгдэнэ. Давагдашгүй хүчин зүйлийг зарлахад тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрлэлийн Танхим буюу түүнтэй адилтгах Засгийн газрын байгууллага гэрчилсэн байна.

14.2. The Party affected by a Force Majeure event may suspend delivery or acceptance of the Concentrates hereunder by giving a prompt written notice thereof to the other Party within 10 working days. The declaration must be evidenced by Chamber of Commerce or similar Government organisation.

14.3. Давагдашгүй хүчин зүйл нь 3 сараас дээш хугацаанд үргэлжилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйлд өртөөгүй тал нь давагдашгүй хүчин зүйлийн хугацаанд нийлүүлэгдэх байсан зэсийн баяжмалын тоо хэмжээг цуцлах тухайгаа нөгөө талдаа бичгээр мэдэгдсэнээр өөрийн хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

14.3. Should the duration of a Force Majeure event exceed three (3) months, the Party who is not affected by a Force Majeure event shall been titled to give a notice in writing to the other Party and cancel the tonnage of the Concentrates, which would have been delivered during the period of a Force Majeure event.

14.4. Давагдашгүй хүчин зүйл нь 12 сараас дээш хугацаанд үргэлжилсэн тохиолдолд Худалдагч болон Худалдан авагч нь нөгөө талдаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцалж болно.

14.4. Should the duration of a Force Majeure event exceed twelve (12) months, either Party shall have the right to terminate this Contract by giving a notice in writing to the other Party.

14.5. Давагдашгүй хүчин зүйл зарласан Тал уг хүчин зүйл дуусгавар болмогц энэ тухайгаа нөгөө талдаа бичгээр цаг алдалгүй мэдэгдэнэ.

14.5. The Party declaring a Force Majeure event shall give a prompt written notice to the other Party when the cause of such Force Majeure event ends.

14.6 Худалдагч давагдашгүй хүчин зүйл зарласан тохиолдолд Худалдан авагчийн төлсөн аливаа урьдчилгаа төлбөрийг Худалдан авагчийн хүсэлтээр Худалдагч буцааж төлнө.

14.6. Where the Seller declares a Force Majeure event, then any outstanding advance payment, at the Buyer's request, shall be immediately repaid by the Seller to the Buyer.

14.7. Худалдан авагчид нийлүүлэхээр галт тэргэнд ачигдсан баяжмалд Худалдан авагч нь

14.7. The Parties agree that in respect of concentrates which have already been loaded on the railway cars for

давагдашгүй хүчин зүйл зарлахгүй байхаар талууд тохиролцов.

14.8. Давагдашгүй хүчин зүйл нь урьд нь ачигдсан баяжмалын эцсийн тооцоо, эсвэл аливаа үүргийг биелүүлэхээс талуудыг чөлөөлөхгүй.

15. ТАТВАР ХУРААМЖ:

15.1. Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон цаашид үүсэн гарч болох аливаа гаалийн татвар, бусад татвар зэрэг бүх зардлыг Худалдагч хариуцна.

15.2 Монголын нутаг дэвсгэрээс гадна талд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон цаашид үүсэн гарч болох аливаа гаалийн болон бусад татвар, зардал төлбөрийг Худалдан авагч хариуцна.

16. ЛИЦЕНЗ:

16.1. Шаардлагатай тохиолдолд экспортын зөвшөөрлийг Худалдагч хугацаанд нь гаргаж өгнө.
16.2. Шаардлагатай тохиолдолд импортын зөвшөөрлийг Худалдан авагч хугацаанд нь гаргаж өгнө.

17. ГЭРЭЭНИЙ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ:

17.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

18. АРБИТР:

18.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргааны асуудлыг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Тэнхимийн дэргэдэх Монголын Олон Улсын арбитрын журмаар шийдвэрлэнэ.

delivery, the Buyer shall not declare a Force Majeure event.

14.8. Force Majeure events shall not enable the Parties to refuse to perform any obligations or any final settlement for the previous concentrate shipments.

15. TARIFFS AND DUTIES:

15.1. All tariffs, taxes and duties on the territory of Mongolia, whether currently existing or imposed after the date of entry into force of this Contract, shall be borne by Seller.

15.2. All tariffs, taxes and duties outside of Mongolia, whether currently existing or imposed after the date of this Contract, shall be borne by Buyer.

16. LICENCES:

16.1. The Seller guarantees hereby the timely issuance of any export license(s), if required.

16.2. The Buyer guarantees hereby the timely issuance of any import license(s), if required.

17. SUCCESSORS AND ASSIGNS:

17.1. Neither Party shall assign this Contract to any Third Party.

18. ARBITRATION:

18.1. Any dispute, controversy or claim arising out of or in connection with this Contract, or the breach, termination, or invalidity thereof, shall be finally settled by arbitration in accordance with the Rules of the Mongolian International Arbitration Court at the Mongolian National Chamber of Commerce and Industry in Ulan-Bator.

18.2. Энэхүү арбитрын шийдвэр эцсийнх бөгөөд хоёр тал харилцан хүлээн зөвшөөрөх ба шаардлагатай бол шүүхэд хандаж болно.

18.2. The award of such arbitration shall be finally binding upon the parties and may be entered in any court having jurisdiction.

18.3. Арбитрын үйл ажиллагаа Монгол улсын Улаанбаатар хотод явагдана.

18.3. The place of arbitration shall be Ulaanbaatar, Mongolia.

18.4. Арбитрын үйл ажиллагаа монгол хэл дээр явагдана.

18.4. The language of the Arbitration should be Mongolian.

19. ХОЛБОГДОХ ХУУЛЬ:

19. GOVERNING LAW:

19.1. Энэхүү гэрээнд Монгол улсын холбогдох хуулиуд хэрэглэгдэнэ.

19.1. The laws of Mongolia shall govern this Contract.

20. МЭДЭГДЭЛ, ЗАХИДАЛ ХАРИЛЦАА:

20. NOTICES AND CORRESPONDENCE:

20.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдлийг Худалдагчид дараах хаягаар илгээнэ:

20.1. All notices and correspondence to the Seller in connection with this Contract shall be sent to the following address:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай 61027

Tel: +976 1352 73791
Fax: +976 70353002

Erdenet Mining Corporation SOE
61027 Nairamdal square, Bayan-Undur soum, Orkhon aimag, Mongolia

Tel: +976 1352 73791
Fax: +976 70353002

20.2. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдлийг худалдан авагчид дараах хаягаар илгээнэ.
Худалдан авагчийн холбоо барих хаяг:

20.2. All notices and correspondence to the Buyer in connection with this Contract shall be sent to:

Buyer’s contact address:

20.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд факс, буухиа шуудангаар болон гараас гарт дээр дурдсан хаягаар эсвэл холбогдох талуудын урьдчилан мэдэгдсэн хаягаар хүргүүлнэ.

20.3. Any notice, to be given hereunder, shall be validly given if in writing and sent by fax, prepaid registered first-class mail, or delivered by hand to the Party to which the notice is directed at the above address or, other address as may be notified by the relevant Party to the other.

20.4. Аливаа мэдэгдлийг факсаар илгээсэн бол 24 цагийн дотор шуудангаар илгээсэн бол 7 хоногийн дотор, гараас гарт бол хүргэсэн цагт нь мэдэгдлийг хүлээн авсанд тооцно.

20.4. Any such notice shall be deemed to have been delivered 24 hours after dispatch if by fax, in 7 days after posting if by mail, or at the time of delivery if by hand.

_____ _____

Erdenet Mining Corporation SOE Buyer’s name

21. НУУЦЛАЛ:

Энэхүү гэрээний зорилго болон нөхцөлийн талаар талууд нөгөө талдаа бичгээр урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүйгээр тохиролцов. Энэхүү заалтыг зөрчвөл гэрээг ноцтой зөрчсөнд тооцогдоно.

21. CONFIDENTIALITY:

Neither Party is entitled to disclose the details of the present Contract to a third party without the prior written consent of the other Party.
Any disclosure in violation of this Clause shall be deemed a material breach of this Contract.

22. БУСАД НӨХЦӨЛ:

Энэ гэрээний үндсэн эхийг Монгол –Англи хэл дээр үйлдсэн бөгөөд монгол, англи хэл дээрх эхийн утга өөр байсан тохиолдолд монгол хэлээр үйлдсэн эхийг баримтална. Энэ гэрээг хоёр хувь үйлдэж талууд хадгалав.

22. OTHER TERMS:

This Contract is made in Mongolian and English, and in the event of any discrepancy, the Mongolian version shall prevail.
This Contract is in 2 (two) copies, one copy for each of the Parties.

Энэхүү гэрээнд цаашид талууд тохиролцсоны дагуу нэмэлт өөрчлөлт хийж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх ба талууд бүрэн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

This Contract may be amended or modified as agreed by the parties in furtherance. The Amendment and changes shall be prepared in writing form and shall be valid after signing by the Parties.

Энэхүү гэрээ болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, хавсралтыг цахим хэлбэрээр (email) солилцож баталгаажуулж болно. Энэ тохиолдолд уг гэрээ болон түүний нэмэлт өөрчлөлт, хавсралт нь хуулийн дагуу хүчин төгөлдөр байна.

This Agreement, including any amendments or appendices, may be confirmed by electronic means (including email). In such a case, the Agreement, along with any amendments or appendices, shall be deemed legally valid and enforceable.

Signed by:

For and on behalf of **Erdenet Mining Corporation SOE:**

“**Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**-ын нэрийн өмнөөс:

G. Yondon _____

General Director

Date: …. …… …….

For and on behalf of**:**

….. компанийн нэрийн өмнөөс:

_____

Date: …. …… …….

_____
Erdenet Mining Corporation SOE

_____
Buyer’s name